

Говь-Алтай аймгийн өсвөр үеийнхний сэтгэцийн тулгамдсан Асуудал үүсэхэд нөлөөлөх зарим хүчин зүйлс

Баярмаа В.¹, Туяа Н.², Ганцэцэг Т.³

¹Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

²“Ач” Анагаах ухааны их сургууль

³Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Анагаах ухааны сургууль

Abstract

Some factors that affect mental health of adolescents

Bayarmaa V.¹, Tuuya N.², Gantsetseg T.³

¹National Center of Mental Health

²“Ach” Medical University

³Mongolian National University of Medical Sciences, School of Medicine

Introduction

In a report from the WHO 2013 it states that, 23% of children between the ages of 13 and 17 had suicidal ideation and 9.3% attempted suicide in the last 12 months. According to the research of Bayarmaa V et al, the prevalence of behavioral and emotional disorder among adolescents is between 8.7% & 9.4%. As a result of these researches, it can be concluded that evaluating the mental health of adolescents and learning the risk factors that can affect it has become an urgent matter in Mongolia.

Goal

To establish the prevalence, the factors that influence it and the type of signs and symptoms common to this behavioral and emotional disorder in adolescents of the Gobi-Altai province.

Material and Method

No ethical errors were reported during the implementation of this study. We used various versions of the Strengths and Difficulties Questionnaire (SDQ) applicable for children, adolescents, parents and teachers and determined exhibition of emotional and behavioral problems by cross-sectional analysis. 2192 adolescents between the ages of 11-18 years old, 1808 parents and caregivers and 102 teachers from the secondary school in Gobi-Altai province were screened from March to December of 2018.

Results

In our study, 50.5% (n=1107) of participants were boys, 49.5% (n=1085) were girls and totally 2192 participants were involved. Regarding the survey results, 58.6% of adolescents in Gobi-Altai province were healthy, 36.1% of them had emotional and behavioral problems and 5.2% of them had emotional and behavioral disorders. For the mental health of adolescent, peer bullying (child 1.4 times higher, parents 6.4 times higher), moving house (child 2 times higher), domestic disputes between parents (child 1.6 times higher), loneliness (child 1.4 times high), hormonal change (teacher 7.7 times high, parents 2 times high), obtaining a qualification for a better life (teacher 6.4 times high) are the factors affecting their mental health negatively and creating a mental health problem.

Conclusion:

58.6% of adolescents in Gobi-Altai province were healthy, 36.1% of them had emotional and behavioral problems and 5.2% of them were with emotional and behavioral disorders. Peer bullying,

moving house, domestic disputes between parents, loneliness, hormonal change are the factors affecting the mental health of adolescents negatively.

Key words: Emotion, behavior, family, friend

Pp. 35-46, Tables 5, Figures 4, References 10

Үндэслэл

Өсвөр насанд охид, хөвгүүдэд биологи, нийгэм, сэтгэлзүйн талаас олон хувирал өөрчлөлтүүд явагддаг бөгөөд аливаа таагүй үйл явдал, тааламжгүй мэдээлэлд өөрийгөө хамгаалах сэтгэл хөдлөл, зан үйлийн талаас өвөрмөц хариу урвал өгдөг.¹ Дэлхий дахинаа хүүхэд, өсвөр насанд 20% нь сэтгэц, зан үйлийн эмгэгтэй байгаа ба сэтгэцийн ихэнх эмгэг хүүхэд, өсвөр насанд эхлэн илэрдэг болохыг ДЭМБ-аас анхааруулдаг.^{2,3} Хэвлэлийн тоймоос үзвэл сургуулийн насны хүүхдийн дунд хамгийн багадаа 3% нь сэтгэл гутралын хүнд хэлбэр, амиа хорлох бодол, солиорол, анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх зэрэг сэтгэцийн эмгэгтэй байдаг ажээ.³

ДЭМБ-ын 2001 оны “Эрүүл мэнд”-ийн тайланд 9-17 насны хүүхдийн дунд сэтгэл түгших эмгэг 13%, зан үйлийн эмгэг 10.3%, сэтгэл хөдлөлийн эмгэг 6.2%-ийн тархалттай байна.⁴ Манай хөрш Оросын Холбооны Улсын Сибирь мужид 2007 онд хийсэн судалгаагаар хүүхэд өсвөр насанд сэтгэцийн тулгамдсан асуудал 15-20%-ийн тархалттай байна.⁵ Америкийн Нэгдсэн Улсын 2009 оны судалгаагаар сургуульд сурч буй өсвөр насныхны 18-22% сэтгэл хөдлөл, зан үйлийн тулгамдсан асуудалтай болохыг тогтоосон байна.⁸ Монгол улсад ДЭМБ-аас хийсэн сэтгэцийн эрүүл мэндийн тогтолцоо (WHO-AIMS)-ны үнэлгээгээр “Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ байхгүй байгаа тул хүүхэд, өсвөр насныханд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ явуулах мэргэжлийн чадамжийг хөгжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй байна” гэж тэмдэглэжээ.¹⁰ Мөн 2013 онд ДЭМБ-аас дэлхий олон орныг хамруулж ЕБС-ийг түшиглэж хийсэн судалгаанд Монгол улсын 13-17 насны өсвөр насныхан сүүлийн 1 жилийн дотор 23 хувь нь амиа хорлох талаар бодож үзсэн бол 9.3 хувь нь амиа хорлох оролдлого хийсэн нь манай улсыг “Өсвөр насны сэтгэцийн эрүүл мэндийн асуудал нь урт удаан хугацаанд нөлөөлөх бодит хямралтай” гэж дүгнэхэд хүргэсэн байна. Манай улсын судлаач В.Баярмаагийн 2018 онд хийсэн судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн дунд сэтгэл хөдлөл,

зан үйлийн эмгэгийн тархалт нь эцэг эхийн үнэлгээгээр 8.7%, багшийн үнэлгээгээр 8.8%, хүүхэд өөрийн үнэлгээгээр 9.4%-ийг эзэлжээ. Иймд хот болон хөдөө орон нутагт өсвөр насны хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх, түүнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг судлах хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байгаа нь уг судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго

Говь-Алтай аймгийн өсвөр насанд түгээмэл тохиолддог сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлүүд, тэдгээрийн тархалт, нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлсийг судлах.

Зорилт:

1. Говь-Алтай аймгийн өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх
2. Өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлүүдийн онцлогийг судлах
3. Өсвөр насныханд сэтгэцийн тулгамдсан асуудлыг үүсгэх зарим эрсдэлт хүчин зүйлсийн судлах

Хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгааны загвар ба хамрах хүрээ: Агшингийн загварыг ашиглаж 2018 оны 3 сараас 10 сарын хооронд Говь-Алтай аймгийн нийт 18 суманд Ерөнхий боловсролын сурууль (ЕБС)-д суралцаж буй 11-18 нийт 2192 сурагч болон тэдний 1808 эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан 102 багшийг хамруулж өсвөр насныхны дунд дахь сэтгэл хөдлөл, зан үйлийн тархалтыг үнэлсэн.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг хүүхэд, эцэг эх/асран хамгаалагч, ангийн багшаас тус тусад нь үнэлдэг тус бүрдээ 25 асуулт бүхий 3 шалгууртай, өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийн хүчтэй ба сул талыг үнэлэхийн зэрэгцээ сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгийг илрүүлдэг стандарт Strengths and Difficulties Questionnaire (SDQ) асуумжийг ашигласан. Энэ асуумж нь өсвөр насныханы сэтгэл хөдлөл, зан үйлийн илэрлийг хэвийн, зааг, хэвийн бус гэсэн

3 хэлбэрээр ялган үнэлдэг аргачлал бөгөөд уг асуумжийг Америкийн Нэгдсэн Улс (2009), Их Британи (1999, 2000, 2014), Австрали (2001), Грек (2009), Норвеги (2011, 2014), БНСУ (2013), БНХАУ (1997, 2005, 2013), ОХУ (2007), Иран (2009, 2013), Бразил (2003), Япон (2014), Герман (2000) зэрэг 100 гаруй оронд ашиглан судалгаа

хийж, 4000 гаруй өгүүлэл хэвлэлүүлсэн байна. Харин Монгол хэлнээ хөрвүүлсэн хувилбарыг online-д www.SDQinfo.com хаягаар нэвтэрч “Mongolian version” танилцах боломжтой бөгөөд 2017 оны нэгдүгээр сараас “Монгол хувилбар”-ыг олон улсад баталгаажуулсан.




Figure 1. Strengths and Difficulties Questionnaire (SDQ)

Мэдээ материал цуглуулсан арга: Судалгааны материалыг 2 үе шаттай цуглуулсан. I шатанд Говь-Алтай аймгийн ЕБС-ийн багш болон нийгмийн ажилтан гэх мэт нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй судлаачийн багийг бүрдүүлж тэдэнд судалгааны асуумж хэрхэн бөглөх талаар сургалт зохион байгуулж судлаач нараа бэлтгэсэн.

II шатанд бэлтгэгдсэн судлаач нар аймгийн төв болон хөдөө суманд ажиллаж ЕБС-д суралцаж буй 11-18 нийт 2192 сурагч болон тэдний 1808 эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан 102 багш нартай нэг бүрчлэн ганцаарчилсан ярилцлага хийж судалгаанд оролцогч нэг бүрт судалгааны ёс зүйн таниулсан зөвшөөрлийн хуудсаа танилцуулан, судалгаанд оролцохыг зөвшөөрч хүүхэд болон эцэг эх асран хамгаалагч хоёулаа гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд мэдээллийг цуглуулсан.

Судалгааны үр дүнгийн боловсруулалт: Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг ЕБС-ийн 2192 хүүхэд, 1808 эцэг эх, 102 анги удирдсан

багш нарын картанд хийхдээ үзүүлэлт тус бүрээр бүлэглэн, SPSS 22.0 программд шивж орууллаа. Судалгааны үр дүнд дескриптив ба нарийвчилсан статистик шинжилгээ хийж, өсвөр насанд түгээмэл тохиолддог сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн, зааг, хэвийн бус, эмгэгийн тархалтыг хувиар илэрхийлж, 95%-ийн итгэх интервалыг тооцов. Хувьсууруудын тархалтыг хэвийн эсэхийг тодорхойлсны дараа үзүүлэлтүүд хоорондын ялгаа, хамаарлыг тооцоход хувиар илэрхийлэгдсэн хувьсууруудад Пирсоны хи квадрат тестийн аргыг, дунджийн ялгааг тооцохдоо т тестийн аргуудыг тус тус ашигласан бөгөөд р-утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистик ач холбогдолтой гэж үзсэн. Өсвөр насанд түгээмэл тохиолддог сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн, зааг, хэвийн бус илрэл, түүнд нөлөөлж буй зарим эрсдэлт хүчин зүйлсийн хамаарлыг тогтоохдоо корреляц, нэг ба олон хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээний аргаар тус тус тооцож, тэдгээрийн итгэх интервалыг тодорхойлов.

Үр дүн

Хүн амзүйн ерөнхий үзүүлэлтүүд: Бидний судалгаанд аймгийн төвийн 249 (11.4%), сумдаас 1943 (11.4%) нийт 2192 хүүхэд хамрагдсаны 50.5% (n=1107) нь хөвгүүд, 49.5% (n=1085) нь охид байв. Судалгаанд хамрагдсан 1808 эцэг эх асран хамгаалагчийн дундаж нас 40.9 ± 10 байсан бол хүйсийн хувьд 69% (n=1247)-ийг эмэгтэйчүүд 31% (n=561)-ийг эрэгтэйчүүд эзэлсэн.

Ам бүлийн тооны дундаж нь 4.7 ± 1.4 , боловсролын түвшин нь 39.8% (n=721) бүрэн дунд, 19.5% (n=352) дээд, 5.9% (n=106) бага боловсролтой байгаа бол 4.9% (n=88) нь боловсролгүй байв. Мэргэжил эзэмшилт, ажил эрхлэлтийн хувьд эцэг эх, асран хамгаалагчдын 42% (n=760) ямар нэг мэргэжил эзэмшээгүй, 6.9% (n=125) хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 8.6% (n=154) ажилчин, 28.7% (n=518) албан хаагч, 13.9% (n=251) малчин ба эцэг эх, асран

хамгаалагчдын 77.5% (n=1402) хууль ёсны гэр бүлтэйгээ хамт амьдардаг бол 2.3% (n=42) салсан тусдаа амьдарч байна. Бид судалгаанд хамрагдсан анги удирдсан 102 багшийн 30.4% (n=31) нь эрэгтэй, 69.6% (n=71) нь эмэгтэй байсан бөгөөд багш нарын дундаж нас 34.7 ± 6.4 , багшийн мэргэжлээрээ ажилласан дунджаар жил нь 11.4 ± 6.4 , тухайн ангийг удирдаж ажилласан дундаж жил нь 3 ± 1.7 тус тус байлаа.

Хүснэгт 1-ээс судалгаанд аймгийн төв (n=127, 51.1%) ба сумд (n=122, 48.9%) -ын хүүхдүүдийг хүйсийн хувьд ойролцоо хувьтай хамруулсан байгаа хэдий ч аймгийн төвд ахлах ангийн сурагчид (n=157, 63.1%), сумдаас дунд ангийн сурагчид (n=1279, 65.8%) арай илүү хамрагдсан байна. Хүүхдийн сурлагын дүнг судлаж үзэхэд В үнэлгээ (n=789, 36.9%), С үнэлгээ (n=651, 30.6%) – тэй хүүхдүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Table 1. Demographical characteristics of participants

Indication	Province center (n=249)		Soum (n=1943)		Total (n=2192)		
	n	percent	n	percent	n	percent	
Gender	Male	127	51.1	980	50.4	1107	50.5
	Female	122	48.9	963	49.6	1085	49.5
Upper and middle grades	Upper grade	157	63.1	664	34.2	821	37.5
	Middle grade	92	36.9	1279	65.8	1371	62.5
	Total	n=249		n=1884		n=2133	
Academic Performance	A*	41	16.5	351	18.6	392	18.4
	B	104	41.8	685	36.4	789	36.9
	C	78	31.3	573	30.4	651	30.6
	D	25	10.0	268	14.2	293	13.7
	F	1	0.4	7	0.4	8	0.4

Тайлбар: *А үнэлгээ 90-100%, *В үнэлгээ 80-89%, *С үнэлгээ 70-79%, *D үнэлгээ 60-69%, E үнэлгээ 50-59%

Сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэл, түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлсийг судалсан байдал

Бид судалгаанд хамрагдагчдаас өсвөр насанд түгээмэл тохиолддог сэтгэл хөдлөл, төрх үйл, анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх байдал, үе тэнгийнхний харилцаа, нийтэч зан үйл гэсэн 5 илрэлийг дискриптив аргаар судалсан.

Хүснэгт 2-оор судалгаанд хамрагдагчдын сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийг хүүхдүүд, асран хамгаалагч ба багш нарын үнэлгээг хүйстэй нь харьцуулж судлахад эцэг эх, асран

хамгаалагчийн үнэлгээгээр үе тэнгийнхний харилцаа (4.16 ± 1.8 , $p < 0.040$), нийтэч зан (7.06 ± 1.8 , $p < 0.0001$) нь хөвгүүдэд охидоос илүү байна гэж үнэлсэн нь статистик ач холбогдол бүхий хамааралтай байна. Харин багшийн үнэлгээгээр хөвгүүдэд сэтгэл хөдлөл (2.34 ± 1.8 , $p < 0.0001$), анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх (3.80 ± 1.8 , $p < 0.003$), үе тэнгийнхний харилцаа (4.22 ± 1.6 , $p < 0.001$) зэрэг нь охидоосоо илүү байсан бол хүүхдүүд өөрсдийгөө үнэлсэн үнэлгээнд охидуудад сэтгэл хөдлөл (4.82 ± 2.2 , $p < 0.033$), нийтэч зан үйл (6.81 ± 1.9 , $p < 0.001$)-ээ хөвгүүдтэй харьцуулахад бага зэрэг дээгүүр

байсан бол хөвгүүдэд анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх (5.22 ± 1.5 , $p < 0.001$) болон үе тэнгийнхний харилцаа (4.71 ± 1.5 , $p < 0.013$) нь

охидоос арай илүү илэрч байгаа нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа.

Table 2. Indications of emotional and behavioral problems compared with gender

	Indication	Male	Female	Total	P value
		Mean \pm SD	Mean \pm SD	Mean \pm SD	
Parents/ Caregivers reports'	Emotional symptoms	3.28 \pm 2.14	3.38 \pm 2.13	3.35 \pm 2.13	0.363
	Conduct problems	2.88 \pm 1.72	2.76 \pm 1.66	2.8 \pm 1.68	0.183
	Hyperactivity problems	4.74 \pm 1.75	4.67 \pm 1.72	4.69 \pm 1.73	0.421
	Peer relationship problems	4.16 \pm 1.83	3.97 \pm 1.81	4.03 \pm 1.82	0.040
	Prosocial behavior	7.06 \pm 1.87	6.68 \pm 1.96	6.80 \pm 1.94	0.0001
	Total score	15.07 \pm 5.59	14.8 \pm 5.37	14.88 \pm 5.44	0.318
Teachers' report	Emotional symptoms	2.34 \pm 1.85	2.08 \pm 1.75	2.16 \pm 1.79	0.003
	Conduct problems	2.26 \pm 1.44	2.18 \pm 1.41	2.21 \pm 1.42	0.268
	Hyperactivity problems	3.80 \pm 1.81	3.55 \pm 1.85	3.63 \pm 1.84	0.003
	Peer relationship problems	4.22 \pm 1.61	3.87 \pm 1.59	3.98 \pm 1.60	0.001
	Prosocial behavior	6.42 \pm 2.18	6.33 \pm 2.22	6.36 \pm 2.21	0.390
	Total score	12.63 \pm 4.15	11.71 \pm 4.13	11.99 \pm 4.15	0.001
Self reports'	Emotional symptoms	4.18 \pm 2.13	4.82 \pm 2.24	4.49 \pm 2.21	0.033
	Conduct problems	2.98 \pm 1.84	2.7 \pm 1.76	2.84 \pm 1.81	0.524
	Hyperactivity problems	5.22 \pm 1.59	5.04 \pm 1.5	5.13 \pm 1.55	0.007
	Peer relationship problems	4.71 \pm 1.5	4.4 \pm 1.39	4.56 \pm 1.45	0.013
	Prosocial behavior	6.49 \pm 1.74	6.81 \pm 1.9	6.65 \pm 1.83	0.001
	Total score	17.1 \pm 4.88	16.98 \pm 4.71	17.04 \pm 4.8	0.584

Хүснэгт 3-аас харахад эцэг эх, асран хамгаалагчдын үнэлснээр анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх нь 11-13 насанд (4.84 ± 1.7 , $p < 0.031$) харьцангуй хүчтэй илэрч, нас ахих тусам буурдаг бөгөөд энэ насанд үе тэнгийнхэнтэйгээ харилцах харьцаа (4.22 ± 1.7 , $p < 0.001$) бусад насны бүлгээсээ илүү байна гэж үнэлсэн нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. Анги удирдсан багш нарын үнэлгээгээр 16-18 насныханд сэтгэл хөдлөл (2.31 ± 1.9 , $p < 0.0001$), төрх үйл (2.22 ± 1.5 , $p < 0.935$) нь харьцангуй хүчтэй илэрдэг гэж үнэлсэн хэдий ч статистикаар батлагдсангүй.

Харин багш нар 14-15 насны хүүхдүүдийн дунд үе тэнгийнхэнтэйгээ харилцах харьцаа (4.20 ± 1.7 , $p < 0.0001$) нь бусад насны бүлгээсээ илүү гэж үнэлсэн бол хүүхдүүд өөрсдийгөө 11-13 насанд төрх үйлийн илрэл (3.01 ± 1.8 , $p < 0.001$), үе тэнгийнхэнтэйгээ харилцах харьцаа (4.76 ± 1.5 , $p < 0.0001$) харьцангуй хүчтэй илэрч, нас ахих тусам буурдаг бол 16-18 насныханд нийтэч зан (6.77 ± 1.8 , $p < 0.039$) харьцангуй их нэмэгддэг гэсэн ялгаатай үзүүлэлтүүд нь статистик ач холбогдол бүхий батлагдаж байна.

Table 3. Indications of emotional and behavioral problems compared with age group

Indication	11-13 y.o	14-15 y.o	16-18 y.o	Total
	Mean \pm SD	Mean \pm SD	Mean \pm SD	Mean \pm SD
Parents/Caregivers' report				
Emotional symptoms	3.36 \pm 2.1***	3.47 \pm 2.1***	3.24 \pm 2.2	3.35 \pm 2.2
Conduct problems	2.74 \pm 1.7	2.99 \pm 1.8	2.71 \pm 1.6	2.80 \pm 1.7
Hyperactivity problems	4.84 \pm 1.7	4.65 \pm 1.8	4.59 \pm 1.7	4.69 \pm 1.7
Peer relationship problems	4.22 \pm 1.7*	4.05 \pm 1.8***	3.82 \pm 1.9*	4.03 \pm 1.7
Pro-social behavior	6.87 \pm 1.9	6.46 \pm 2.0	7.00 \pm 1.8	6.8 \pm 1.9

Total score	15.17±5.3*	15.18±5.5	14.37±5.5*	14.88±5.4**
Teachers' report				
Emotional symptoms	1.92±1.7***	2.26±1.7***	2.31±1.9	2.16±1.8
Conduct problems	2.19±1.3	2.21±1.4	2.22±1.5	2.21±1.4
Hyperactivity problems	3.67±1.8	3.71±1.8	3.53±1.9	3.63±1.8
Peer relationship problems	4.02±1.7*	4.20±1.7***	3.77±1.5*	3.98±1.6
Pro-social behavior	6.48±2.2	6.33±2.1	6.28±2.2	6.36±1.6
Total score	11.81±3.9*	12.38±3.9	11.85±4.5*	11.99±4.2*
Self-reports				
Emotional symptoms	4.42±2.2	4.45±2.2	4.60±2.1	4.49±2.2
Conduct problems	3.01±1.8*	2.88±1.9*	2.67±1.6***	2.85±1.8
Hyperactivity problems	5.18±1.5	5.12±1.6	5.10±1.5	5.13±1.5
Peer relationship problems	4.76±1.5*	4.61±1.5	4.34±1.3***	4.56±1.5
Pro-social behavior	6.53±1.8	6.62±1.8	6.77±1.8*	6.65±1.8
Total score	17.38±4.8*	17.08±5.1	16.72±4.4*	17.05±4.8*

* $p < 0.05$, ** $p < 0.001$, *** $p < 0.0001$

Мөн хүүхдүүд 16-18 насныханд сэтгэл хөдлөл (4.60 ± 2.1 , $p < 0.231$) бусад насны бүлэгтэй харьцуулахад харьцангуй хүчтэй илэрдэг гэж үнэлсэн боловч энэ нь статистикаар батлагдсангүй. Иймд бид нийт онооны үзүүлэлтээр нь судалж үзлээ. SDQ асуумжийн аргачлалд сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийг эцэг эх, асран хамгаалагчийн үнэлгээгээр 14-16 оноо, багшийн үнэлгээгээр 12-15 оноо авсан тохиолдолд хэвийн ба хэвийн бус байдлын зааг гэж үнэлдэг. Харин бидний судалгаанд эцэг эх, асран хамгаалагчийн үнэлгээний дундаж оноо 14.88 ± 5.4 , ($p < 0.010$), багш нарын үнэлгээний дундаж оноо 11.99 ± 4.2 , ($p < 0.021$), хүүхдийн үнэлгээний дундаж оноо 17.05 ± 4.8 , ($p < 0.025$) байгаа нь судалгаанд хамрагдсан хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийн дундаж оноо хэвийн ба хэвийн бус байдлын заагт байгааг нь статистик ач холбогдол бүхий батлагдав. Эндээс харахад өсвөр насныханы дунд сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлүүд нь насны бүлгээсээ хамаарч харилцан адилгүй илэрч байна.

Судалгаанд хамрагдагсдын сэтгэл хөдлөл, зан үйлийн талаар эцэг эх, асран хамгаалагчийн өгсөн үнэлгээний дундаж үзүүлэлтийг хүйс ба

аймгийн төв, хөдөөгийн сумдтай харьцуулж судлахад эцэг эхийн үнэлгээгээр хөдөө сумын охидод сэтгэл хөдлөл (3.57 ± 2.01 , $p < 0.000$), аймгийн төвийн охидод нийтэч зан (7.58 ± 1.6 , $p < 0.016$) хөвгүүдээсээ илүү хүчтэй илэрч байна. Харин анги удирдсан багшийн үнэлгээгээр төрх үйлийн (аймгийн төв 2.06 ± 1.5 , $p < 0.015$, сумдад 2.41 ± 1.5 , $p < 0.000$) болон анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх (аймгийн төв 4.25 ± 1.6 , $p < 0.000$, сумдад 3.86 ± 2.0 , $p < 0.000$) зэрэг илрэлүүд нь хөвгүүдэд охидоосоо арай хүчтэй, нийтэч зан (аймгийн төв 5.53 ± 2.1 , $p < 0.000$, сумдад 6.17 ± 2.1 , $p < 0.000$) сул илэрсэн нь статистик ач холбогдол бүхий байв. Харин анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх нь аймгийн төвийн хөвгүүдэд (4.25 ± 1.6 , $p < 0.000$) сумдын хөвгүүдээс арай хүчтэй илэрч байгаа бол төрх үйлийн илрэл нь сумдын хөвгүүдэд (2.41 ± 1.5 , $p < 0.000$) арай илүү илэрч байна.

Харин нийтэч зан (аймгийн төв 6.95 ± 2.1 , $p < 0.000$, сумдад 6.58 ± 2.2 , $p < 0.000$) хөвгүүдээс охидод илүү тод илэрсэн. Аймгийн төвийн охидод анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх (3.53 ± 1.2 , $p < 0.000$), нийтэч зан (аймгийн төв 6.95 ± 2.1 , $p < 0.000$) зэрэг нь сумын охидтой харьцуулахад харьцангуй хүчтэй илэрч байна.




Figure 2. Normal, abnormal and borderline ranges of emotional and behavioral problems

Нийт онооны үзүүлэлтээр хэвийн болон зааг, хэвийн бус байдлыг үнэлж үзэхэд: Эцэг эх, асран хамгаалагчийн үнэлгээгээр 33.4% (n=603) нь “Хэвийн бус”, 23.9% (n=432) нь “Зааг”, 42.8% (n=773) нь “Хэвийн”, багшийн үнэлгээгээр 19.7% (n=426) нь “Хэвийн бус”, 32.1% (n=694)


нь “Зааг”, 48.2% (n=1041) нь “Хэвийн”, хүүхэд өөрийн үнэлгээгээр 29.4% (n=645) нь “Хэвийн бус”, 30.3% (n=664) нь “Зааг”, 40.3% (n=883) нь “Хэвийн” түвшинд байна гэж тус тус үнэлжээ (Зураг 2).

Table 4. Results of (Strengths & Difficulties Questionnaire) SDQ impact supplements

Impact	Parents report		Teachers report		Self-report	
	Yes	No	Yes	No	Yes	No
Difficulties upset child	708 (39.2)	1100 (60.8)	469 (20.3)	1723 (79.7)	1416 (64.6)	776 (35.4)
Difficulties distress child	360 (19.9)	1448 (80.1)	240 (11.2)	1921 (88.9)	1019 (46.5)	1173 (53.5)
Interfere with HOME LIFE	241 (13.3)	1567 (86.7)			503 (22.9)	1689 (77.1)
Interfere with CLASSROOM	270 (14.9)	1538 (85.1)	296 (13.7)	1865 (86.3)	839 (38.3)	1353 (61.7)
Interfere with LEARNING			276 (12.8)	1885 (87.2)		
Interfere with LEISURE ACTIVITIES	260 (14.4)	1548 (85.6)			756 (34.5)	1436 (65.5)
Interfere with all life spans	218 (12.1)	1590 (87.9)	273 (12.6)	1888 (87.4)	623 (31.6)	1499 (68.4)

Хүснэгт 4-өөс харахад хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн зааг буюу хэвийн бус байдал нь хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлж буйг асран хамгаалагч, багш, хүүхдээс асуумжийн аргаар судлахад эцэг эх, асран хамгаалагчдын 39.2% (n=708), багш нарын 20.3% (n=469) нь, хүүхдүүдийн 64.6% (n=1416) нь амьдралд нь их бага ямар нэг хэмжээгээр нөлөөлдөг гэж үзсэн байна. Тиймээс цааш тодруулж судлахад эцэг эх, асран хамгаалагчдын 19.9% (n=360) хүүхэд өөрөө хямардаг, гэртээ байхад нь сөргөөр нөлөөлдөг 55% (n=1077) гэсэн хариултууд, багш нарын 13.7% (n=296) анги хамт олонд байхад нь сөргөөр нөлөөлдөг, 12.8% (n=276) суралцах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг,

11.2% (n=240) хүүхэд өөрөө хямардаг гэсэн хариултуудыг тус тус өгсөн бол хүүхдийн 46.5% (n=1019) би өөрөө хямарч тавгүйдэг, 57.6% (n=1128) чөлөөтэй байхад сөргөөр нөлөөлдөг, 38.3% (n=839) ангийн хамт олон дунд байхад нь сөргөөр нөлөөлдөг гэсэн хариултуудыг түлхүү өгчээ. Мөн сэтгэл хөдлөл, зан үйлийн зааг буюу хэвийн бус илрэлүүд нь хүүхдийн бүхий л амьдралд нь нөлөөлж, хүндрэл учруулдаг гэж асран хамгаалагч 12.1% (n=218), багш 12.6% (n=273), хүүхэд 31.6% (n=623) нь үнэлсэн байна. Тиймээс бид сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлүүд нь хэр хугацаагаар үргэлжилж байгааг судалж үзлээ.

**Figure 4. Duration (month, year) of emotional and behavioral problems**

Зураг 3-аас харахад эцэг эх, асран хамгаалагч 26.9%, багш нар 15.4%, хүүхэд 41.1% нь 1 сараас доош хугацаагаар үргэлжилсэн гэж үнэлсэн бол 1-5 сарын хооронд үргэлжилсэн гэж эцэг эх, асран хамгаалагчдын 8.2%, багш нарын 3.1%, хүүхдүүдийн 13.6% нь хариулжээ. Харин эцэг эх, асран хамгаалагчийн 4%, багш нарын 1.7%, хүүхдийн 9.8% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус илрэлүүд 6 сараас дээш хугацаагаар үргэлжилсэн гэж хариулсан байна. Эндээс харвал АНУ-ын DSM-V ангиллын “Сэтгэл хөдлөл ба зан үйлийн эмгэг” гэж оношилдог оношилгооны шалгуурын дагуу үнэлэхэд Говь-Алтай аймгийн ЕБС-д суралцаж байгаа 13-18 настай хүүхдүүдийн дунд эцэг эх, асран хамгаалагчийн үнэлгээгээр 4%, багш нарын үнэлгээгээр 1.7%, хүүхдийн үнэлгээгээр 9.8% (n=215) нь “Сэтгэл хөдлөл, зан үйлийн

эмгэг”-тэй байх боломжтой байна.

Хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж буй зүйлийг тодруулах зорилгоор хүүхэд, эцэг эх, багш нараас асуумж авлаа. Хүүхдүүдийн үзэж байгаагаар сайхан амьдрахын төлөө сайн сурах (n=890, 40.6%) гэж хичээж суралцах, багшийн үнэлгээгээр эцэг эх, нийгэмтэйгээ харьцах харилцаанд гарах өөрчлөлт (n=559, 25.9%), үе тэнгийнхний дарамт шахалт (n=551, 23.6%), эцэг эх, асран хамгаалагчийн үнэлгээгээр сайхан амьдрахын төлөө сайн сурах (n=395, 21.8%) эцэг эх, нийгэмтэйгээ харьцах харилцаанд гарах өөрчлөлт (n=294, 16.3%) зэрэг хүчин зүйлс нь хүүхдийн эрүүл мэнд сэтгэл санааны байдалд сөргөөр нөлөөлж байна гэж түлхүү хариулсан байлаа (Зураг 4).




Figure 5. Results of emotional risk factors regarding the reports of children, parents, and teachers

Тиймээс бид олон хүчин зүйлийн логистик регрессийн аргыг ашиглаж сэтгэл зүйд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийн статистик ач холбогдлыг үнэлсэн.

Table 5. Results of emotional risk factors (impact multiple factors of logistics regression)

Risk factors	Total		Wald	Sig.	Exp (B)	95% Confidence		
	n	%				Lower	Upper	
Self report'								
Peer pressure	Yes	503	22.9%	6.317	0.012	1.496	1.093	2.049
	No	1689	77.1%					
Moving to new residence	Yes	146	6.7%	9.051	0.003	2.021	1.278	3.197
	No	2046	93.3%					
Conflict between parents	Yes	234	10.7%	6.438	0.011	1.666	1.123	2.472
	No	1958	89.3%					
Loneliness	Yes	399	18.2%	4.708	0.030	1.458	1.037	2.049
	No	1793	81.8%					
Inability to handle stress	Yes	388	17.7%	2.914	0.088	1.351	0.956	1.909
	No	1804	82.3%					
P< 0.000, r2=0.026								
Teachers report								
Hormonal changes	Yes	360	16.7%	33.066	0.000	7.763	3.861	15.610
	No	1801	83.3%					
Peer pressure	Yes	511	23.6%	1.428	0.232	0.477	0.142	1.606
	No	1650	76.4%					
Family divorce	Yes	380	17.6%	1.525	0.217	0.280	0.037	2.110
	No	1781	82.4%					
Learn to live well	Yes	388	18.0%	27.068	0.000	6.487	3.207	13.120
	No	1773	82.0%					
P< 0.000, r2=0.218								
Parents report								
Hormonal changes	Yes	292	16.2%	7.365	0.007	2.082	1.226	3.536
	No	1516	83.8%					
Peer pressure	Yes	275	15.2%	9.275	0.002	2.253	1.336	3.801
	No	1533	84.8%					
Sexually transmitted infections	Yes	162	9.0%	3.738	0.053	0.141	0.019	1.027
	No	1646	91.0%					

P< 0.000, r2=0.040

Хүснэгт 5-аас харахад хүүхдийн үнэлгээгээр үе тэнгийнхний дарамт шахалт (n=503, 22.9%), гэр орон шилжиж нүүх (n=146, 6.7%), эцэг, эхийн хэрүүл маргаан, үл ойлголцол (n=234, 10.7%), ганцаардал (n=399, 18.2%), стрессээ тайлах чадваргүй байх (n=388, 17.7%) зэрэг хүчин зүйлс нь нэгэн зэрэг тохиолдоход хүүхдийн сэтгэл хөдлөл зан үйлд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг 3 орчим хувиар (P<0.000, r2=0.026) нэмэгдүүлж байна. Ялангуяа үе тэнгийнхний дарамт шахалт, гэр орон шилжин суурьших, эцэг, эхийн

хэрүүл маргаан, үл ойлголцол, ганцаардал зэрэг эрсдэлт хүчин зүйлс нь дан дангаараа тохиолдох нь хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх эрсдэл шууд болохыг харуулж байна. Тухайлбал: үе тэнгийнхний дарамт шахалт (P<0.012, OR=1.496, 95% CI=1.093-2.049) үе тэнгийнхний дарамт шахалтанд өртөөгүй хүүхэдтэй харьцуулахад 1.4 дахин их, гэр орон нь шилжин суурьших (P<0.003, OR=2.021, 95% CI=1.278-3.197) нь суурьшмал амьдралтай хүүхдээс 2 дахин их, эцэг, эхийн хэрүүл маргаан,

үл ойлголцол нь ($P < 0.011$, $OR = 1.666$, $95\% CI = 1.123-2.472$) нь тайван гэр бүлд өсөж байгаа хүүхдээс 1.6 дахин их, хүүхэд ганцаардах нь ($P < 0.030$, $OR = 1.458$, $95\% CI = 1.037-2.049$) нь ганцаардаагүй хүүхдээс 1.4 дахин их хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Багшийн үнэлгээгээр дааврын өөрчлөлт ($n = 360$, 16.7%), үе тэнгийнхний дарамт шахалт ($n = 511$, 23.6%), гэр бүл салалт ($n = 360$, 16.7%), сайн сурах, амьдрахын төлөө хэт хичээх ($n = 388$, 18%) зэрэг хүчин зүйлс нь нэгэн зэрэг тохиолдоход хүүхдийн сэтгэл хөдлөл зан үйлд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг 22 хувьд ($P < 0.000$, $r^2 = 0.026$) буюу ойролцоогоор 5 хүүхэд тутмын нэгэнд нөлөөлөх боломжтой бөгөөд дааврын өөрчлөлт, сайн сурах, амьдрахын төлөө хэт хичээх зэрэг эрсдэлт хүчин зүйлс нь дан дангаараа тохиолдох нь хүүхдийн сэтгэл зүйд шууд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тухайлбал: дааврын өөрчлөлт ($P < 0.000$, $OR = 7.763$, $95\% CI = 3.861-15.610$) нь 7.7 дахин их, сайн сурах, амьдрахын төлөө хэт хичээх ($P < 0.000$, $OR = 6.487$, $95\% CI = 3.207-13.120$) нь 6.4 дахин их хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй нь статистикаар ач холбогдол бүхий батлагдлаа.

Эцэг эх, асран хамгаалагчийн үнэлгээгээр дааврын өөрчлөлт ($n = 292$, 16.2%), үе тэнгийнхний дарамт шахалт ($n = 275$, 15.2%), бэлгийн замын халдвар авах ($n = 162$, 9%) зэрэг хүчин зүйлс нь нэгэн зэрэг тохиолдоход хүүхдийн сэтгэл хөдлөл зан үйлд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг 4 хувиар ($P < 0.000$, $r^2 = 0.026$) нэмэгдүүлэх боломжтой бөгөөд дааврын өөрчлөлт, үе тэнгийнхний дарамт шахалт зэрэг эрсдэлт хүчин зүйлс нь дан дангаараа тохиолдох нь хүүхдийн сэтгэл зүйд шууд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тухайлбал: дааврын өөрчлөлт ($P < 0.007$, $OR = 2.082$, $95\% CI = 1.226-3.536$) нь 2 дахин их, үе тэнгийнхний дарамт шахалт ($P < 0.002$, $OR = 2.253$, $95\% CI = 1.336-3.801$) нь 6.4 дахин их хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр статистикаар ач холбогдол бүхий нөлөөлж байна.

Хэлцэмж

Өсвөрийн үед (шилжилтийн нас, бэлэг бойжилтын нас) охид, хөвгүүдэд биологи (физиологи, бие махбодын), нийгэм сэтгэлзүйн олон хувирал өөрчлөлтүүд явагддаг бөгөөд аливаа таагүй үйл явдал, тааламжгүй мэдээлэлд өөрийгөө хамгаалах өвөрмөц сэтгэлзүйн өөрчлөлт (сэтгэл хөдлөл, зан үйлийн өөрчлөлт) бүхий хариу урвал өгдөг бөгөөд сургуулийн насны хүүхдийн дунд хамгийн багаар бодоход

3% нь сэтгэл гутралын хүнд хэлбэр, амиа хорлох бодол, солиорол, анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх зэрэг сэтгэцийн ямар нэг эмгэгтэй байдаг гэж судлаачид үздэг. Тиймээс дэлхий нийтээрээ сүүлийн үед өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал хандуулж Strengths and Difficulties Questionnaire (SDQ) буюу “Хүчтэй ба сул талын тухай асуумж”-ийг ашиглаж дэлхийн олон улс орон өөрийн орны өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлж байна. SDQ хэмээх асуумж нь хүүхэд болон эцэг эх асран хамгаалагч, анги удирдсан багш нараас нэгэн зэрэг мэдээллийг цуглуулдаг давуу талтай, хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг хэвийн, зааг, хэвийн бус гэсэн 3 хэлбэрээр үнэлдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал юм. Тиймээс бид уг судалгаанд энэхүү асуумжийг ашигласан.

Судлаач В. Баярмаа нарын 2013 онд хөдөөгийн 10 аймаг, Улаанбаатараас 7 дүүргээс нийт 72 сургуулийг сонгон хамруулан 2250 хүүхэд, 2250 эцэг эх, 72 багшийг хамруулж өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийг үнэлсэн Монгол улсын өсвөр насныхныг төлөөлхүйц томоохон судалгааны дүнгээс үзэхэд өсвөр насныхны 60.5% нь сэтгэцийн хувьд эрүүл, 30.5% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 9% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байлаа. Харин Говь-Алтай аймгийн өсвөр насныхны 58.6% нь сэтгэцийн хувьд эрүүл, 5.2% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байгаа нь улсын дунджаас бага зэрэг доогуур байгаа хэдий ч сэтгэцийн тулгамдсан асуудалтай (36.1%) хүүхдийн эзлэх хувь улсын дунджаас ялимгүй их байна. Энэ нь Говь-Алтай аймгийн боловсрол-эрүүл мэнд-нийгэм хамгаалал зэрэг салбар хэлтсүүдээс гадна өрх гэр, эцэг асран хамгаалагч нарыг хүүхдийн хүмүүжилд анхаарах, сурч, амьдрах нөхцөл боломжийг нь сайжруулах, эрүүл аюулгүй орчинд өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлэх зэргээр хүүхэд өсвөр насныхан уруу чиглэсэн дорвитой ажил хийх цаг болсныг харуулж байна. Дээрх судалгаагаар сэтгэцийн тулгамдсан асуудал, сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэг үүсэхэд гэр бүлийн бүтэц, гэр бүлийн архидалт, эцэг эх нь хүүхэдтэйгээ хамт амьдрахгүй байх зэрэг нь нөлөөлж байна. Харин бидний судалгаагаар өсвөр насныхны сэтгэл зүйд үе тэнгийнхний дарамт шахалт (хүүхэд-1.4, эцэг эх-6.4 дахин их,) гэр орон нь шилжин суурьших (хүүхэд-2 дахин их), эцэг, эхийн хэрүүл маргаан, үл ойлголцол (хүүхэд-1.6 дахин их) ганцаардал (хүүхэд-1.4 дахин) дааврын

өөрчлөлт (багш-7.7, эцэг эх-2 дахин их) сайн сурах, амьдрахын төлөө хэт их хичээх (багш-6.4 дахин их) зэрэг эрсдэлт хүчин зүйлс нь сөргөөр нөлөөлж сэтгэцийн тулгамдсан асуудлыг үүсгэж байна гэсэн дээрх судалгаатай ойролцоо үр дүн гарлаа.

Дүгнэлт:

1. Говь-Алтай аймгийн өсвөр насныхны 58.6% нь сэтгэцийн хувьд эрүүл, 36.1% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 5.2% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байна.
2. Өсвөр насныхны дунд сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлүүд нь насны бүлгээсээ хамаарч харилцан адилгүй ялгаатай байна. Тухайлбал: анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх нь 11-13 насанд харьцангуй хүчтэй илэрч, нас ахих тусам буурдаг бол 14-15 насны хүүхдүүдийн дунд үе тэнгийнхэнтэйгээ харилцах харьцаа бусад насны бүлгээсээ илүү, 16-18 насныханд сэтгэл хөдлөл, төрх үйлийн илрэлүүд нь харьцангуй хүчтэй илрэх хандлага илэрч нийтэч зан харьцангуй их нэмэгддэг гэсэн ялгаатай үзүүлэлтүүд ажиглагдлаа.
3. Өсвөр насныхны сэтгэл зүйд үе тэнгийнхний дарамт шахалт (хүүхэд-1.4, эцэг эх-6.4 дахин их,) гэр орон нь шилжин суурьших (хүүхэд-2 дахин их), эцэг, эхийн хэрүүл маргаан, үл ойлголцол (хүүхэд-1.6 дахин их) ганцаардал (хүүхэд-1.4 дахин) дааврын өөрчлөлт (багш-7.7, эцэг эх-2 дахин их) сайн сурах, амьдрахын төлөө хэт их хичээх (багш-6.4 дахин их) зэрэг эрсдэлт хүчин зүйлс нь сөргөөр нөлөөлж сэтгэцийн тулгамдсан асуудлыг үүсгэж байна.

Ном зүй

1. Бямбасүрэн С. Сэтгэцийн эмгэг судлал. Улаанбаатар: Сэлэнгэ пресс ХХК; 2013.
 2. В.Баярмаа, Н.Алтанзул, Н.Туяа, Б.Жаргал, Т.Ганцэцэг, Д.Болорчимэг, Л.Насанцэнгэл
- Өсвөр үеийнхэнд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ. 2018 он
3. Organization WH, Association WP, Child IAf, Psychiatry A, Professions A. Atlas: child and adolescent mental health resources: global concerns, implications for the future. World Health Organization; 2005.
 4. Aiko Moriwaki, Yoko Kamio Normative data and psychometric properties of the strengths and difficulties questionnaire among Japanese

school-aged children. Child and Adolescent Psychiatry and Mental Health, 2014

5. Kieling C, Baker-Henningham H, Belfer M, et al. Child and adolescent mental health worldwide: evidence for action. The Lancet. 2011; 378 (9801):1515-1525.
6. Organization WH. The World Health Report 2001: Mental health: new understanding, new hope. World Health Organization; 2001.
7. Slobodskaya HR, Akhmetova OA, Ryabichenko TI. Siberian child and adolescent mental health: Prevalence estimates and psychosocial factors. Alaska medicine. 2007; 49 (2):261.
8. Гудман Р, Скотт С. Детская психиатрия. Vol 2. Москва: Издательство "Триада-Х"; 2008.
9. Meltzer H, Gatward R, Goodman R, Ford T. The mental health of children and adolescents in Great Britain. HM Stationery Office; 2000.
10. Merikangas KR, Nakamura EF, Kessler RC. Epidemiology of mental disorders in children and adolescents. Dialogues in clinical neuroscience. 2009; 11 (1):7.

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор, профессор
Л.Насанцэнгэл*